



ҮНДЭСНИЙ  
СТАТИСТИКИЙН  
ХОРОО

ЭДИЙН ЗАСГИЙН  
ХӨГЖИЛД  
**ЖИЖИГ, ДУНД**  
**ҮЙЛДВЭРЛЭЛИЙН**  
ОРУУЛЖ БУЙ ХУВЬ  
НЭМЭР

**2020**



ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛД  
ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН  
ОРУУЛЖ БУЙ ХУВЬ НЭМЭР  
2020 ОНД

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

Вэб хаяг: [www.nso.mn](http://www.nso.mn) , [www.1212.mn](http://www.1212.mn)

Утас: 1900-1212

Танилцуулгыг бэлтгэсэн:

БХАГ-ын ҮТХ-ийн дарга Б.Баярмаа

Утас: 51-262767

Танилцуулгыг хянасан:

БХАГ-ын дарга Б.Саранчимэг

## Гарчиг

Товчилсон үгийн жагсаалт.....	3
Хүснэгтийн жагсаалт .....	4
Зургийн жагсаалт .....	4
Оршил.....	5
Нэг. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн тоо.....	6
Хоёр. Жижиг, дунд үйлдвэрлэлийн эдийн засагт оруулж буй хувь нэмэр.....	7
2.1 ЖДҮ-ийн нэмэгдэл өртөг, үйл ажиллагааны салбараар .....	8
2.2 ЖДҮ-ийн нэмэгдэл өртөг, бүс, аймгаар.....	11
2.3 ЖДҮ-ийн экспорт .....	12
ДҮГНЭЛТ .....	13

### Товчилсон үгийн жагсаалт

ААН	Аж ахуйн нэгж
ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
ГЕГ	Гаалийн Ерөнхий Газар
ДНБ	Дотоодын Нийт Бүтээгдэхүүн
ЖДҮ	Жижиг, дунд үйлдвэрлэл
ЖДҮҮЭ	Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч
НӨ	Нэмэгдэл өртөг
ХАА	Хөдөө аж ахуй
ХХЭ	Хувиараа хөдөлмөр эрхлэгч

### **Хүснэгтийн жагсаалт**

- ХҮСНЭГТ 1. ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЭЛДЭГ АЖ АХУЙН НЭГЖИЙН ТОО, ажиллагчдын тооны бүлэг, борлуулалтын орлогын бүлгээр
- ХҮСНЭГТ 2. ДНБ, ЖДҮ-ИЙН НЭМЭГДЭЛ ӨРТӨГ
- ХҮСНЭГТ 3. ЖДҮ-ИЙН НЭМЭГДЭЛ ӨРТӨГ, салбараар
- ХҮСНЭГТ 4. ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН НЭМЭГДЭЛ ӨРТӨГ, төрлөөр
- ХҮСНЭГТ 5. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРЫН НЭМЭГДЭЛ ӨРТӨГ, төрлөөр
- ХҮСНЭГТ 6. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН НЭМЭГДЭЛ ӨРТӨГ, төрлөөр
- ХҮСНЭГТ 7. ЖДҮ-ИЙН НЭМЭГДЭЛ ӨРТӨГ, бүс, аймгаар, тэрбум төгрөг
- ХҮСНЭГТ 8. ЖДҮ-ИЙН ЭКСПОРТ, голлох бараагаар

### **Зургийн жагсаалт**

- ЗУРАГ 1. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН ХУУЛИЙН ЭТГЭЭД БОЛОН ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧДИЙН ТОО, жил бүрийн эцэст
- ЗУРАГ 2. ЖДҮҮЭ ААН-ИЙН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТИЙН БҮТЭЦ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР
- ЗУРАГ 3. ЖДҮ-ИЙН ЭДИЙН ЗАСАГТ ОРУУЛЖ БУЙ ХУВЬ НЭМЭР (ДНБ-Д ЭЗЛЭХ ХУВЬ)
- ЗУРАГ 4. ДНБ БОЛОН ЖДҮ-ИЙН НЭМЭГДЭЛ ӨРТГИЙН САЛБАРЫН БҮТЭЦ
- ЗУРАГ 5. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРЫН ЖДҮ-ИЙН НЭМЭГДЭЛ ӨРТӨГ
- ЗУРАГ 6. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ЖДҮ-ИЙН НЭМЭГДЭЛ ӨРТӨГ
- ЗУРАГ 7. ЖДҮ-ИЙН НЭМЭГДЭЛ ӨРТГИЙН БҮТЭЦ, БҮСЭЭР
- ЗУРАГ 8. ЖДҮ-ИЙН ЭКСПОРТ
- ЗУРАГ 9. ЖДҮ-ИЙН ЭКСПОРТ, улс орноор

## Оршил

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ гэж ажиллах хүчний болон үйлдвэрлэлийн цар хүрээгээр цомхон, бүтээмж өндөртэй, үйлдвэрлэлийн уян хатан технологитой, зах зээлд өрсөлдөх чадвар бүхий бизнесийг ойлгоно.

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний салбарт хамгийн олон хүн ажиллаж, эдийн засагт тодорхой хувь нэмэр оруулдаг. Тийм ч учраас жижиг, дунд үйлдвэр ямар бүтээгдэхүүн, үйлчилгээ хүргэж, ямар техник технологи ашиглаж, хэр бүтээмжтэй ажиллаж байгаа нь тухайн улсын “Хөгжлийн толь” болдог гэж үздэг.

Монгол Улсын Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль анх 2007 онд батлагджээ. Уг хуулиар ажиллагчдын тоо нь 199-өөс дээшгүй бөгөөд 1.5 тэрбум төгрөг хүртэлх жилийн борлуулалтын орлого бүхий үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэнийг жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч гэж тодорхойлж байсан.

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2019 оны 6 дугаар сард батлагдсан.

ҮСХ жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийн тоог статистикийн бизнес регистрийн сангаас “Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай” хуулийн 3.2, 4.1.1, 7.1-р заалтыг үндэслэн тодорхойлж гаргадаг. Тус хуулийн

- 3.2-д төрийн бус байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой компани, улсын төсөвт үйлдвэрийн газар, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой газар, гадаад улсын хуулийн этгээд энэ хуулийн зохицуулалтад хамаарахгүй;
- 4.1.1-д “Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч” гэж 200 хүртэл ажилтантай, жилийн 2.5 тэрбум төгрөг хүртэл борлуулалтын орлоготой, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийг;
- 7.1-д жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид хамаарахгүй этгээдийг заасан байдаг.

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид хамаарахгүй салбаруудыг<sup>1</sup> эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллын дагуу авч үзвэл, 18 салбарын нийт 108 анги (салбарын ангиллын 4 оронгийн түвшин) байна.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 156 дугаар тогтоолоор “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийг баталсан. Уг хөтөлбөрийн үр дүнд жижиг, дунд үйлдвэр хөгжин ажлын байр шинээр нэмэгдэнэ, түүнчлэн иргэд аж ахуйн нэгж байгуулан, шинээр ажлын байр бий болгох хандлага нэмэгдэнэ гэж үзсэн байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр 2020 оны зорилтот түвшинд идэвхтэй үйл ажиллагаа эрхэлж байгаа жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч 64.9 мянга, жижиг, дунд үйлдвэрийн экспортод эзлэх хувь 3.5 гэж тодорхойлсон байна.

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгаар жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид хувиараа хөдөлмөр эрхлэгчид буюу албан бус секторт ажиллагчдыг хамруулж авч үзэхээ больсон.

Албан бус сектор гэж хөдөө аж ахуйн бус салбарт орлого олох зорилготойгоор зах зээлд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ борлуулдаг өрхийн хоршоологдоогүй аж ахуй нэгж буюу хувиараа хөдөлмөр эрхлэгчийг ойлгоно.

Энэхүү танилцуулгад жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн бий болгосон нэмэгдэл өртгийн хэмжээг эдийн засгийн үйл ажиллагааны салбар болон бүс нутгаар нэгтгэн, үр дүнг 2015-2020 оноор харууллаа.


---

<sup>1</sup> Дэлгэрэнгүй жагсаалтыг Статистикийн бизнес регистр танилцуулгаас харах боломжтой

## Нэг. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн тоо

Статистикийн бизнес регистрийн сангийн мэдээллээр 2020 оны жилийн эцсийн байдлаар 63.2 мянган жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид (ЖДҮҮЭ) үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээдийн 66.9 хувийг эзэлж байна.

**ЗУРАГ 1. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН ХУУЛИЙН ЭТГЭЭД БОЛОН ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧДИЙН ТОО, ЖИЛ БҮРИЙН ЭЦЭСТ**



Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг:

- бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч (10 хүртэл ажилтантай, жилийн 300.0 сая төгрөг хүртэл борлуулалтын орлоготой аж ахуйн нэгж),
- жижиг үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч (10-50 хүртэл ажилтан, жилийн 300.0 сая-1.0 тэрбум төгрөг хүртэл борлуулалтын орлоготой аж ахуйн нэгж),
- дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч (50-200 хүртэл ажилтан, жилийн 1.0-2.5 тэрбум төгрөг хүртэл борлуулалтын орлоготой аж ахуйн нэгж) гэж ангилсан байна.

ЖДҮҮЭ-ийг борлуулалтын орлогын бүлгээр нь харьцуулбал, жилийн 300.0 сая төгрөг хүртэл борлуулалтын орлоготой ЖДҮҮЭ-ийн тоо 2020 онд өмнөх оноос 0.8 хувиар буурч, жилийн 300.0 сая - 1.0 тэрбум төгрөгийн болон 1.0-2.5 тэрбум төгрөгийн борлуулалттай ЖДҮҮЭ-ийн тоо 4.4-6.6 хувиар нэмэгдсэн байна.


**ХҮСНЭГТ 1. ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЭЛДЭГ АЖ АХУЙН НЭГЖИЙН ТОО, АЖИЛЛАГЧДЫН ТООНЫ БҮЛЭГ, БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫН БҮЛГЭЭР**

Борлуулалтын орлого Ажиллагчдын тооны бүлэг	2019				2020			
	Бүгд	300.0 сая хүртэл төгрөг	0.3 -1.0 тэрбум төгрөг	1.0-2.5 тэрбум төгрөг	Бүгд	300.0 сая хүртэл төгрөг	0.3-1.0 тэрбум төгрөг	1.0-2.5 тэрбум төгрөг
<b>Нийт</b>	<b>63 131</b>	<b>55 709</b>	<b>5 159</b>	<b>2 263</b>	<b>63 177</b>	<b>55 295</b>	<b>5 508</b>	<b>2 374</b>
1-10	58 907	52 984	4 305	1 618	59 236	52 844	4 638	1 754
10-50	3 837	2 521	774	542	3 596	2 279	804	513
50-200	387	204	80	103	345	172	66	107

ЖДҮҮЭ-ийн тоо 2020 онд өмнөх онтой харьцуулбал (Зураг 2),

- 53.1 мянга (84.1%) - үйл ажиллагаагаа хэвийн явуулсан,
- 2.3 мянга (3.6%) - борлуулалтын орлого нэмэгдэж, бүлгийн хэмжээнд өөрчлөлт орсон,
- 2.8 мянга (4.4%) - борлуулалтын орлого буурч, бүлгийн хэмжээнд өөрчлөлт орсон,
- 5.0 мянга (7.9%) - ЖДҮҮЭ болж нэмэгдэж орсон, үүнээс 1.8 мянга (42.5%) нь өмнөх онд том ААН байсан бөгөөд борлуулалтын орлого нь буурч, ЖДҮҮЭ-д шилжсэн байна.

## ЗУРАГ 2. ЖДҮҮЭ-ИЙН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТИЙН БҮТЭЦ, дүнд эзлэх хувиар



Өөрчлөлтийн бүтцийг сүүлийн 2 оноор харьцуулбал, үйл ажиллагаагаа хэвийн явуулсан ЖДҮҮЭ-ийн тоо 2020 онд 2019 оноос 3.0 нэгж хувиар нэмэгдэж, ЖДҮҮЭ-д нэмэгдсэн нэгжийн тоо 3.8 нэгж хувиар буурсан байна.

## Хоёр. Жижиг, дунд үйлдвэрлэлийн эдийн засагт оруулж буй хувь нэмэр

Коронавируст халдварын цар тахалтай холбоотой хямрал нь манай улсын эдийн засагт, ялангуяа жижиг, дунд үйлдвэрлэл (ЖДҮ)-д шууд нөлөөлж байна.

Монгол Улсын Засгийн газраас Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх үүднээс нийгэм, эдийн засгийн хүрээнд хэрэгжүүлсэн бодлого, шийдвэр нь эдийн засгийн бүх салбарын үйл ажиллагаа тодорхой хэмжээгээр буурахад нөлөөлсөн.

Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 04 сарын 29-ний өдөр “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуулийг баталсан. Энэ хуулийн зорилт нь коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, хүний эрхэд тодорхой хязгаарлалт хийх, холбогдох шийдвэрийг шуурхай гаргах, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, зохион байгуулалтын асуудлыг Засгийн газар онцгой журмаар шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Монгол Улсын Засгийн газар Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах арга хэмжээний хүрээнд 2020 онд 2 дугаар сарын 12-ны өдөр “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” тогтоол гаргасан. Үүнээс хойш 2020 онд бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах, бууруулах тухай тогтоолыг 15 удаа гаргасан байна.

Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэхтэй холбоотой тогтоосон арга хэмжээ нь үйлчилгээ, хүнсний бус боловсруулах үйлдвэрлэл, аялал жуулчлал, боловсрол, соёл урлаг, дотоодын тээвэр, гадаад худалдаа зэрэг салбарын ЖДҮ эрхлэгчдийн үйл ажиллагаанд бусад салбараас илүүтэй нөлөөлсөн бол уул уурхай, олборлолт, хөдөө аж ахуй, эрүүл мэнд, хүнсний чиглэлийн боловсруулах үйлдвэр, мэдээлэл, харилцаа холбоо, ачаа тээвэр (нүүрс) зэрэг салбарт харьцангуй бага нөлөөлсөн.

## ХҮСНЭГТ 2. ДНБ, ЖДҮ-ИЙН НЭМЭГДЭЛ ӨРТӨГ


Төрөл	ДНБ <sup>2</sup> , тэрбум төгрөг		ДНБ-д эзлэх хувь		Жилийн өөрчлөлт, хувиар	
	2019	2020	2019	2020	2019	2020
ЖДҮ	1 330.9	1 810.0	4.1	5.6	16.3	36.0
ЖДҮ-д хамаарахгүй	30 832.1	30 385.7	95.9	94.4	17.4	-1.5
Бүгд	32 162.9	32 195.7	100.0	100.0	17.3	0.1

ЖДҮ-д бий болгосон нэмэгдэл өртгийн хэмжээ 2020 онд 1.8 их наяд төгрөг болж, өмнөх оноос 474.0 тэрбум төгрөг буюу 36.0 хувиар нэмэгджээ. ЖДҮ-ийн эдийн засагт оруулах хувь нэмэр буюу ДНБ-д эзлэх хувь 5.6 болж, өмнөх оноос 1.5 нэгж хувиар нэмэгдсэн байна.

<sup>2</sup> ДНБ, үндсэн үнээр, мөн үл хөдлөх хөрөнгийн салбарт тусгадаг Өөрийн эзэмшлийн орон сууцны хийсвэр түрээсийн тооцооллыг оруулаагүй.



**ЗУРАГ 3. ЖДҮ-ИЙН ЭДИЙН ЗАСАГТ ОРУУЛЖ БУЙ ХУВЬ НЭМЭР (ДНБ-д эзлэх хувь)**



**2.1 ЖДҮ-ийн нэмэгдэл өртөг, үйл ажиллагааны салбараар**

ЖДҮ-ийн үйл ажиллагааг эдийн засгийн салбараар авч үзвэл, хөдөө аж ахуйн салбарын ЖДҮ-ийн нэмэгдэл өртгийн ДНБ-д эзлэх хувь 2020 оны гүйцэтгэлээр 15.0, үйлдвэрлэлийн салбарынх 8.2, үйлчилгээний салбарынх 6.6 боллоо (Хүснэгт 2).

**ХҮСНЭГТ 3. ЖДҮ-ИЙН НЭМЭГДЭЛ ӨРТӨГ, салбараар**

	ДНБ <sup>2</sup>			ЖДҮ-ийн нэмэгдэл өртөг			ЖДҮ-ийн НӨ-ийн салбарын НӨ-т эзлэх хувь	
	2019	2020	<u>2020</u> 2019	2019	2020	<u>2020</u> 2019	2019	2020
	хувь			хувь				
<b>Бүгд</b>	<b>32 162.9</b>	<b>32 195.7</b>	<b>100.1</b>	<b>1 330.9</b>	<b>1 810.0</b>	<b>136.0</b>	<b>4.1</b>	<b>5.6</b>
Хөдөө аж ахуй	4 373.6	4 856.1	111.0	82.4	88.4	107.3	1.9	1.8
Үйлдвэрлэл	14 414.0	13 876.3	96.3	332.8	486.6	146.2	2.3	3.5
Уул уурхай, олборлолт	9 590.1	8 722.1	90.9	-	-	-	-	-
Боловсруулах	2 675.1	2 904.9	108.6	149.5	207.4	138.7	5.6	7.1
Цахилгаан, хий, уур, усан хангамж	819.9	881.8	107.6	4.1	5.3	130.8	0.5	0.6
Барилга	1 328.9	1 367.5	102.9	179.2	273.9	152.9	13.5	20.0
Үйлчилгээ	13 375.3	13 463.3	100.7	915.7	1 234.9	134.9	6.8	9.2
Худалдаа	3 644.1	3 436.8	94.3	463.4	632.6	136.5	12.7	18.4
Тээвэр	1 686.9	1 411.8	83.7	83.4	131.8	158.0	4.9	9.3
Байр, сууц, нийтийн хоол	399.6	321.4	80.4	71.1	85.2	119.8	17.8	26.5
Бусад үйлчилгээ	7 644.7	8 293.3	108.5	297.8	385.4	129.4	3.9	4.6

**ЗУРАГ 4. ДНБ БОЛОН ЖДҮ-ИЙН НЭМЭГДЭЛ ӨРТГИЙН САЛБАРЫН БҮТЭЦ**



ДНБ-д хөдөө аж ахуйн салбар 15.1 хувь, үйлдвэрлэлийн салбар 43.1 хувь, үйлчилгээний салбар 41.8 хувийг эзэлж байгаа бол ЖДҮ-ийн нэмэгдэл өртгийн 26.9 хувь нь үйлдвэрлэлийн салбарт, 68.2 хувь нь үйлчилгээний салбарт ногдож байна.

### 2.1.1 Хөдөө аж ахуйн салбар

Манай улсын хувьд хөдөө аж ахуйд мал аж ахуйн салбар зонхилдог, хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртгийн 92.0 хувийг мал аж ахуй, 7.0 хувийг газар тариалан, 1.0 хувийг ойн аж ахуй, хөдөө аж ахуйн бусад салбар бүрдүүлдэг. Иргэд, малчид ЖДҮ-д хамаарахгүй учир (шинэчилсэн хуулийн дагуу) ХАА-н салбарын ЖДҮ-ийн нэмэгдэл өртөг салбартаа дунджаар 1.6 хувь байна.

#### ХҮСНЭГТ 4. ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН НЭМЭГДЭЛ ӨРТӨГ, төрлөөр, тэрбум төгрөг

Төрөл	2015	2016	2017	2018	2019	2020
<b>Хөдөө аж ахуй</b>	<b>3 223.4</b>	<b>3 022.0</b>	<b>3 119.6</b>	<b>3 723.5</b>	<b>4 373.6</b>	<b>4 856.1</b>
ЖДҮ	42.8	53.4	31.4	71.8	82.4	88.4
ЖДҮ-д хамаарахгүй	3 180.6	2 968.7	3 088.2	3 651.8	4 291.2	4 767.6
ЖДҮ-ийн дүнд эзлэх хувь	1.3	1.8	1.0	1.9	1.9	1.8

### 2.1.2 Үйлдвэрлэлийн салбар

Үйлдвэрлэлийн салбар нь 2020 онд ДНБ<sup>2</sup>-ий 43.1 хувийг бүрдүүлсэн бол уг салбарын ЖДҮ-ийн нэмэгдэл өртгийн хэмжээ салбартаа 3.5 хувийг бүрдүүлжээ.

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийн тодорхойлолтын дагуу үйлдвэрлэл эрхлэгч ЖДҮ-д уул уурхай, олборлолтын салбар, цахилгаан, хий, уур, ус хангамж, ундаа үйлдвэрлэл, тамхи үйлдвэрлэл, металл боловсруулах, төмөр зам, авто замын байгууламж барих үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага болон төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, байгууллага, гадаадтай хамтарсан, гадаад улсын байгууллагууд хамаарахгүй учир үйлдвэрлэлийн салбарын ЖДҮ-ийн нэмэгдэл өртгийн хэмжээ харьцангуй бага түвшинд байна.

#### ХҮСНЭГТ 5. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРЫН НЭМЭГДЭЛ ӨРТӨГ, төрлөөр, тэрбум төгрөг

Төрөл	2015	2016	2017	2018	2019	2020
Үйлдвэрлэл	7 215.5	7 940.0	10 481.2	12 373.5	14 414.0	13 876.3
ЖДҮ	195.7	251.1	193.9	292.7	332.8	486.6
ЖДҮ-д хамаарахгүй	7 019.8	7 688.9	10 287.2	12 080.7	14 081.2	13 389.7
ЖДҮ-ийн дүнд эзлэх хувь	2.7	3.2	1.9	2.4	2.3	3.5
Үүнээс:						
Уул уурхай, олборлолт	4 150.5	4 822.7	7 007.9	8 370.8	9 590.1	8 722.1
ЖДҮ	-	-	-	-	-	-
ЖДҮ-д хамаарахгүй	4 150.5	4 822.7	7 007.9	8 370.8	9 590.1	8 722.1
ЖДҮ-ийн дүнд эзлэх хувь	-	-	-	-	-	-
Боловсруулах үйлдвэрлэл	1 606.2	1 595.6	1 932.2	2 298.1	2 675.1	2 904.9
ЖДҮ	99.1	100.7	95.7	133.6	149.5	207.4
ЖДҮ-д хамаарахгүй	1 507.1	1 494.9	1 836.5	2 164.5	2 525.6	2 697.6
ЖДҮ-ийн дүнд эзлэх хувь	6.2	6.3	5.0	5.8	5.6	7.1
Цахилгаан, хий, уур, усан хангамж	540.5	618.8	635.5	718.8	819.9	881.8
ЖДҮ	2.4	2.8	2.8	3.5	4.1	5.3
ЖДҮ-д хамаарахгүй	538.1	616.0	632.6	715.3	815.8	876.5
ЖДҮ-ийн дүнд эзлэх хувь	0.4	0.5	0.4	0.5	0.5	0.6
Барилга	918.3	902.9	905.6	985.7	1 328.9	1 367.5
ЖДҮ	94.2	147.5	95.4	155.6	179.2	273.9
ЖДҮ-д хамаарахгүй	824.2	755.3	810.2	830.2	1 149.7	1 093.6
ЖДҮ-ийн дүнд эзлэх хувь	10.3	16.3	10.5	15.8	13.5	20.0

## ЗУРАГ 5. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРЫН ЖДҮ-ИЙН НЭМЭГДЭЛ ӨРТӨГ



Үйлдвэрлэлийн салбарын ЖДҮ-ийн бий болгосон нэмэгдэл өртгийн хэмжээ 2020 онд 486.6 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 46.2 хувиар нэмэгдсэн байна.

Үйлдвэрлэлийн салбарын ЖДҮ-ийн нэмэгдэл өртгийн хэмжээ тухайн салбарын 3.5 хувийг, нийт ЖДҮ-ийн нэмэгдэл өртөгт 26.9 хувийг эзэлж байна.

### 2.1.3 Үйлчилгээний салбар

Үйлчилгээний салбар (оны үнээр) 2020 онд ДНБ<sup>2</sup>-ий 41.8 хувийг бүрдүүлсэн. Үйлчилгээ эрхлэгч ЖДҮ-ийн нэмэгдэл өртгийн хэмжээ нийт үйлчилгээний салбарын 4.7 хувийг бүрдүүлжээ.

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийн тодорхойлолтын дагуу үйлчилгээ эрхлэгч ЖДҮ-д санхүү, даатгал, үл хөдлөх хөрөнгө, төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, боловсрол, гишүүнчлэл бүхий байгууллагын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага болон төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, байгууллага, гадаадтай хамтарсан, гадаад улсын байгууллагууд хамаарахгүй.

## ХҮСНЭГТ 6. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН НЭМЭГДЭЛ ӨРТӨГ, төрлөөр, тэрбум төгрөг

Төрөл	2015	2016	2017	2018	2019	2020
<b>Үйлчилгээ</b>	<b>9 127.1</b>	<b>9 540.0</b>	<b>10 338.8</b>	<b>11 324.1</b>	<b>13 375.3</b>	<b>13 463.3</b>
ЖДҮ	371.8	463.6	436.3	417.6	463.4	632.6
ЖДҮ-д хамаарахгүй	8 755.3	9 076.4	9 902.5	10 906.5	12 912.0	12 830.8
ЖДҮ-ийн дүнд эзлэх хувь	4.1	4.9	4.2	3.7	3.5	4.7
Үүнээс:						
Бөөний, жижиглэн худалдаа	2 664.8	2 621.3	2 867.8	3 090.2	3 644.1	3 436.8
ЖДҮ	371.8	463.6	436.3	417.6	463.4	632.6
ЖДҮ-д хамаарахгүй	2 293.0	2 157.7	2 431.5	2 672.7	3 180.8	2 804.2
ЖДҮ-ийн дүнд эзлэх хувь	14.0	17.7	15.2	13.5	12.7	18.4
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	1 202.4	1 274.4	1 318.7	1 538.7	1 686.9	1 411.8
ЖДҮ	40.2	36.3	30.1	59.3	83.4	131.8
ЖДҮ-д хамаарахгүй	1 162.2	1 238.1	1 288.6	1 479.4	1 603.5	1 280.0
ЖДҮ-ийн дүнд эзлэх хувь	3.3	2.9	2.3	3.9	4.9	9.3
Байр, сууц, хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	220.6	262.7	277.6	344.5	399.6	321.4
ЖДҮ	49.6	60.3	46.6	72.9	71.1	85.2
ЖДҮ-д хамаарахгүй	170.9	202.4	230.9	271.7	328.5	236.2
ЖДҮ-ийн дүнд эзлэх хувь	22.5	22.9	16.8	21.1	17.8	26.5
Бусад үйлчилгээ	5 039.4	5 381.6	5 874.7	6 350.6	7 644.7	8 293.3
ЖДҮ	224.3	178.5	201.2	230.6	297.8	385.4
ЖДҮ-д хамаарахгүй	4 815.0	5 203.1	5 673.5	6 120.1	7 346.9	7 907.9
ЖДҮ-ийн дүнд эзлэх хувь	4.5	3.3	3.4	3.6	3.9	4.6

## ЗУРАГ 6. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ЖДҮ-ИЙН НЭМЭГДЭЛ ӨРТӨГ




Үйлчилгээний салбарын ЖДҮ-ийн бий болгосон нэмэгдэл өртгийн хэмжээ 2020 онд 632.6 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 36.5 хувиар нэмэгджээ. Үйлчилгээний салбарын ЖДҮ-ийн нэмэгдэл өртгийн хэмжээ тухайн салбарын 4.7 хувийг, нийт ЖДҮ-ийн нэмэгдэл өртөгт 68.2 хувийг эзэлж байна.

## 2.2 ЖДҮ-ийн нэмэгдэл өртөг, бүс, аймгаар

ЖДҮ-ийн нэмэгдэл өртгийг бүсээр авч үзвэл, 2020 оны байдлаар баруун бүсэд 4.1 хувь, хангайн бүсэд 7.6 хувь, төвийн бүсэд 11.2 хувь, зүүн бүсэд 3.1 хувь, Улаанбаатарт 74.0 хувь нь ногдож байна.

### ЗУРАГ 7. ЖДҮ-ИЙН НЭМЭГДЭЛ ӨРТГИЙН БҮТЭЦ, бүсээр



### ХҮСНЭГТ 7. ЖДҮ-ИЙН НЭМЭГДЭЛ ӨРТӨГ, бүс, аймгаар, тэрбум төгрөг

	ДНБ <sup>2</sup>			ЖДҮ-ийн нэмэгдэл өртөг			ЖДҮ-ийн НӨ-ийн ДНБ-д эзлэх хувь	
	2019	2020	<u>2020</u> 2019	2019	2020	<u>2020</u> 2019	2019	2020
	хувь			хувь				
<b>Бүгд</b>	<b>32 162.9</b>	<b>32 195.7</b>	<b>100.1</b>	<b>1 330.9</b>	<b>1 810.0</b>	<b>136.0</b>	<b>4.1</b>	<b>5.6</b>
<b>Баруун бүс</b>	<b>2 059.2</b>	<b>2 349.8</b>	<b>114.1</b>	<b>53.6</b>	<b>75.1</b>	<b>140.0</b>	<b>2.6</b>	<b>3.2</b>
Баян-Өлгий	404.2	447.0	110.6	8.6	12.2	142.3	2.1	2.7
Говь-Алтай	329.7	405.3	122.9	7.5	10.9	145.6	2.3	2.7
Завхан	417.5	480.6	115.1	8.2	9.6	117.0	2.0	2.0
Увс	387.8	464.8	119.8	14.9	20.5	137.5	3.8	4.4
Ховд	520.0	552.1	106.2	14.5	21.9	151.5	2.8	4.0
<b>Хангайн бүс</b>	<b>4 735.7</b>	<b>4 666.5</b>	<b>98.5</b>	<b>96.7</b>	<b>136.7</b>	<b>141.3</b>	<b>2.0</b>	<b>2.9</b>
Архангай	591.0	630.0	106.6	8.5	10.8	126.6	1.4	1.7
Баянхонгор	437.2	554.4	126.8	7.4	10.0	135.8	1.7	1.8
Булган	358.6	390.2	108.8	12.0	16.5	137.1	3.4	4.2
Орхон	2 042.3	1 797.9	88.0	34.1	57.7	169.1	1.7	3.2
Өвөрхангай	625.1	633.0	101.3	14.7	20.5	139.4	2.3	3.2
Хөвсгөл	681.7	661.0	97.0	20.0	21.2	106.2	2.9	3.2

<b>Төвийн бүс</b>	<b>3 415.7</b>	<b>3 980.4</b>	<b>116.5</b>	<b>149.8</b>	<b>202.4</b>	<b>135.1</b>	<b>4.4</b>	<b>5.1</b>
Говьсүмбэр	105.2	118.8	113.0	3.4	5.2	154.8	3.2	4.4
Дархан-Уул	488.4	619.0	126.8	29.6	48.5	164.2	6.1	7.8
Дорноговь	437.7	478.5	109.3	13.3	16.8	126.4	3.0	3.5
Дундговь	361.7	337.2	93.2	5.9	8.6	144.9	1.6	2.5
Өмнөговь	775.3	981.2	126.6	34.7	48.0	138.2	4.5	4.9
Сэлэнгэ	642.5	765.0	119.1	33.2	39.3	118.2	5.2	5.1
Төв	605.0	680.7	112.5	29.8	36.1	121.2	4.9	5.3
<b>Зүүн бүс</b>	<b>1 887.7</b>	<b>1 676.8</b>	<b>88.8</b>	<b>44.1</b>	<b>56.8</b>	<b>128.9</b>	<b>2.3</b>	<b>3.4</b>
Дорнод	924.8	756.2	81.8	23.3	30.4	130.6	2.5	4.0
Сүхбаатар	502.0	455.6	90.8	6.6	10.4	158.8	1.3	2.3
Хэнтий	460.9	465.0	100.9	14.2	16.0	112.5	3.1	3.4
<b>Улаанбаатар</b>	<b>20 064.6</b>	<b>19 522.2</b>	<b>97.3</b>	<b>986.6</b>	<b>1 339.0</b>	<b>135.7</b>	<b>4.9</b>	<b>6.9</b>

### 2.3 ЖДҮ-ийн экспорт


Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид 2020 онд 532.7 тэрбум төгрөгийн бараа экспортод гаргасан нь нийт барааны экспорт<sup>3</sup>-ын 2.5 хувийг эзэлж байна. ЖДҮ-ийн экспортын хэмжээ жил бүр нэмэгдэж байгаа хэдий ч ЖДҮ-ийн экспортод эзлэх хувь төдийлэн өөрчлөлтгүй байна.

#### ЗУРАГ 8. ЖДҮ-ИЙН ЭКСПОРТ



ЖДҮ-ийн экспортыг гаргаж байгаа улс орнуудаар авч үзвэл, БНХАУ руу 2020 онд 481.7 тэрбум төгрөгийн бараа экспортлосон байна. Энэ нь ЖДҮ-ийн экспортын 90.4 хувийг эзэлж байгаа бөгөөд 2015 онтой харьцуулахад 11.4 нэгж хувиар нэмэгджээ.

#### ЗУРАГ 9. ЖДҮ-ИЙН ЭКСПОРТ, улс орноор



ЖДҮ-ийн экспортод гаргасан барааг ангилан авч үзвэл 2020 онд экспортын 53.6 хувь нь мал, амьтны ноос, ноолуур, 29.5 хувь нь эрдэс бүтээгдэхүүний экспорт эзэлж байна.

<sup>3</sup> ГЕГ-ын мэдээгээр

## ХҮСНЭГТ 8. ЖДҮ-ИЙН ЭКСПОРТ, голлох бараагаар

Барааны бүлэг	HS код	2015	2016	2017	2018	2019	2020	2016	2018	2020
		тэрбум төгрөг							дүнд эзлэх хувь	
Мах; мал, амьтны гаралтай бусад бүтээгдэхүүн	02,05	14.9	14.3	11.1	30.0	50.8	16.9	4.9	7.7	3.2
Самар	08	16.2	49.4	45.3	17.2	0.2	0.4	16.7	4.4	0.1
Тослог үр жимс	12	28.4	29.7	12.4	18.4	26.8	17.3	10.1	4.7	3.3
Махан бүтээгдэхүүн	16	1.3	2.5	0.7	60.0	10.2	17.0	0.9	15.4	3.2
Эрдэс бүтээгдэхүүн	25-27	62.0	89.3	101.3	92.1	80.4	157.3	30.3	23.6	29.5
Боловсруулсан арьс шир	41	25.2	9.8	27.3	24.7	22.2	7.3	3.3	6.3	1.4
Мал, амьтны ноос, ноолуур	51	66.6	48.7	129.2	115.2	258.0	285.3	16.5	29.5	53.6
Сүлжмэл хувцас	61	1.8	3.8	4.9	13.2	10.9	13.8	1.3	3.4	2.6
Бусад бараа	-	4.7	47.6	8.3	19.7	33.5	17.3	16.1	5.0	3.2
<b>Бүгд</b>		<b>221.1</b>	<b>295.3</b>	<b>340.5</b>	<b>390.6</b>	<b>493.0</b>	<b>532.7</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>

### ДҮГНЭЛТ

Коронавируст халдварын цар тахалтай холбоотой хямрал нь манай улсын эдийн засагт, ялангуяа жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд шууд нөлөөлж байна.

Монгол Улсын Засгийн газар Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээний хүрээнд 2020 онд бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай, бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах, бууруулах тухай тогтоолыг 16 удаа гаргасан байна.

Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэхтэй холбоотой тогтоосон арга хэмжээ нь үйлчилгээ, хүнсний бус боловсруулах үйлдвэрлэл, аялал жуулчлал, боловсрол, соёл урлаг, дотоодын тээвэр, гадаад худалдаа болон бусад салбарын жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд бусад салбараас илүүтэй нөлөөлсөн бол уул уурхай, олборлолт, хөдөө аж ахуй, эрүүл мэнд, хүнсний чиглэлийн боловсруулах үйлдвэр, мэдээлэл харилцаа холбоо, ачаа тээвэр (нүүрс) зэрэг салбарт харьцангуй бага нөлөөлсөн.

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид 2020 онд нийт аж ахуйн нэгж, байгууллагын 66.9 хувийг эзэлж, ЖДҮ 1.8 их наяд төгрөгийн нэмэгдэл өртөг бий болгосон нь ДНБ-ий 5.6 хувийг, хувиараа хөдөлмөр эрхлэгч буюу албан бус секторт үйл ажиллагаа эрхлэгчид 1.1 их наяд төгрөгийн нэмэгдэл өртөг бий болгосон нь ДНБ-ий 3.5 хувийг эзэлж байна.

Үйлдвэрлэлийн салбарын ЖДҮ-ийн нэмэгдэл өртгийн хэмжээ 2020 онд 486.6 тэрбум төгрөг, албан бус секторынх 249.2 тэрбум төгрөг болж, үйлдвэрлэлийн салбарын нэмэгдэл өртөгт ЖДҮ 3.5 хувь, албан бус сектор 1.8 хувийг эзэлж байна.

Үйлчилгээний салбарын ЖДҮ-ийн нэмэгдэл өртгийн хэмжээ 2020 онд 632.6 тэрбум төгрөг болж, үйлчилгээний салбарын нэмэгдэл өртөгт 4.7 хувийг эзэлж байна.

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид 2020 онд 532.7 тэрбум төгрөгийн бараа экспортолсон нь нийт барааны экспортын 2.5 хувийг эзэлж байна. Экспортын 90.4 хувийг БНХАУ-д гаргасан бол экспортын барааны 53.6 хувь нь мал, амьтны ноос, ноолуур, 29.5 хувь нь эрдэс бүтээгдэхүүний байна.

Эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзвэл ЖДҮ-ийн нэмэгдэл өртгийн 4.9 хувийг хөдөө аж ахуйн салбар, 26.9 хувийг үйлдвэрлэлийн салбар, 68.2 хувийг үйлчилгээний салбар эзэлж байна.